

ОУИТБС-ын ТӨВИЙН БҮСИЙН IV ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

2021.05.28

Улаанбаатар хот

“Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Төвийн бүсийн IV чуулган” 2021 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд цахим /онлайн/-аар зохион байгуулагдаж, УУХҮЯ, СЯ, БОАЖЯ, АМГТГ, ТЕГ, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул, Орхон аймгийн ЗДТГ зэрэг төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын, МУУҮА, Нүүрс Ассоциаци, Рио Тинто ХХК, Оюу толгой ХХК, Бороо гоулд ХХК зэрэг хувийн хэвшлийн, Төлсөн Авснаа Нийтэл ТББ-ын эвслийн төлөөлөл, Бичил уурхай эрхлэгчдийн дээвэр холбоо зэрэг бичил уурхайн, Олон улсын санхүүгийн корпораци, Мерит төсөл зэрэг олон улсын донор байгууллагуудын, болон ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, алба, Дэд зөвлөлийн төлөөллүүд тус тус оролцлоо.

Чуулганд оролцогчид ОУИТБС-ыг орон нутагт идэвхжүүлэх, түүний Дэд зөвлөлийг чадавхжуулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах зөвлөмжүүдийг гаргахаар тогтов. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд:

- 1.1. Чуулганд танилцуулсан хуулиудын төслийг, ялангуяа Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төслийг анхаарч, батлуулах ажлыг яаравчлах;
- 1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрхийг орон нутагт хэвээр үлдээх заалтыг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгах;
- 1.3. Эрдэс баялгийн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд тухайн орон нутгийнхаа дэд зөвлөлийн чадавх бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлж байх албан хүсэлтийг УУХҮЯ-наас хүргүүлэх;
- 1.4. УУХҮ-ийн сайд, Аймгуудын ЗД-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг жилийн эцэст дүгнэх, Дэд зөвлөлийн үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулах;
- 1.5. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийг батлуулахдаа Дэд зөвлөлийн санхүүжилтийн асуудлыг суулган, эцэслэн шийдвэрлүүлэх;
- 1.6. Эрдэс баялгийн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн нэг үндсэн зорилт энэ салбарын засаглалыг сайжруулахад чиглэсэн байдаг учир Дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, бэхжүүлэх, жигдрүүлэхэд тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргах асуудлыг судлах;
- 1.7. Уул уурхайн салбарын өгөөжийн талаар тодорхой баримттай, ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэх асуудлыг судлан шийдвэрлэх;
- 1.8. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд яамны зүгээс ямар арга хэмжээ авах бололцоотойгоо мэдээлэх, холбогдох журмын тодорхой заалтыг албажуулах;
- 1.9. УУХҮЯ нь орон нутагт салбартай байх, холбогдох арга хэмжээг авах;
- 1.10. ОУИТБС-ын түүхэн өгөгдөл мэдээллийн ашиглалтыг бий болгох, төрийн бодлогыг боловсруулахдаа эдгээр мэдээллийг ашигладаг байх;

2. Сангийн Яаманд:

- 2.1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулах, ЗГ-ын 236-р тогтоолын СЯ-нд өгсөн үүргийн заалтын хэрэгжилтийг хангах, бусад эх үүсвэрийг баталгаажуулах;
- 2.2. Олборлох үйлдвэрлэлээс Улсын төсөвт төвлөрүүлж буй орлогын 1 хувийг ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд зарцуулах, Орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй орлогын 1 хувийг

аймгуудын Дэд зөвлөл, түүний үйл ажиллагаанд тогтвортой санхүүжүүлэх эх үүсвэр болгох;

- 2.3. Шилэн дансны тухай хуулиар уул уурхайн компаниудаас төсөвт байгууллагад өгсөн хандивыг мэдээлдэг байхаар журам гаргах, тайлагнах үйл ажиллагааг тодорхой болгох, хүлээн авсан татварын буюу орон нутгийн төсвийн зарцуулалтын тайланг гаргадаг болох журмыг хамтад гарган хэрэгжүүлэх;
- 2.4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр, байгууллагууд хоорондоо мэдээллээ солилцох, уялдаа холбоогоо сайжруулахад анхаарах;
- 2.5. Уул уурхайн орлогоос бүрэлдэж буй Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх арга зүйг судлан, шийдвэрлэх;
- 2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг иргэдийн саналаар ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой эсэх талаар Сангийн яамнаас тодорхой удирдамж, зөвлөмжийг аймгуудад албан тоотоор хүргүүлэх;

3. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд:

- 3.1. Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн хэмжээг үндэслэлтэй болгох талаар судалгаа хийлгэх, бодитой тогтоох арга хэмжээ авах;
- 3.2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан боловсруулах, тайлагнах журмаар аймгийн Засаг даргын оролцоо байхгүй болсон тул үүнийг өөрчилж, орон нутгийн удирдлагын санал авдаг байхаар журамлах
- 3.3. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд яамны зүгээс ямар арга хэмжээ авах бололцоотойгоо мэдээлэх, зарим журмын тодорхой заалтыг албажуулах г.м.
- 3.4. Бичил уул уурхай эрхлэх өнөөгийн журмыг шинэчлэх, эрх мэдэл хэтрүүлэх явдлыг таслан зогсоох;
- 3.5. Бичил бичил уурхайг эрхлэгчдийн одоо байгаа мэдээлэлд түшиглэн үнэлэх, нийтэд хариуцлагатай бичил уурхайчдыг ил тод зарлах, мэдээллийн сан бий болгох;

4. Ашигт малтмал, газрын тосны газарт:

- 4.1. Тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн саналыг хоцорсон байсан ч хүлээж авч, дүгнэлт хийсний дараа тусгай зөвшөөрөл олгодог болох;
- 4.2. Орон нутагт олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн системтэй байх;
- 4.3. Дараа дараагийн бүсийн чуулган болон бусад арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцох;

5. Төвийн бүсийн аймгуудын Засаг дарга нарт:

- 5.1. Аймгийн Засаг даргаас олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг АМГТГ-ын кадастрын системд улирал бүр солилцож, шинэчлэх;
- 5.2. Дэд зөвлөлийн гишүүдээ сургах талаар хамтран ажиллах;
- 5.3. Аймаг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг аймаг сумдын ОУИТБС-ын Дэд зөвлөлд оруулах, мэдээллийн хүртээмжээ нэмэгдүүлэх;
- 5.4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн талаар холбогдох байгууллагууд хоорондоо уялдаа холбоотой байх, мэдээллээ солилцох, одоогийн нөхцөл байдлаа сайжруулах;
- 5.5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө сумын удирдлага, иргэдийн саналыг авах;
- 5.6. Том, жижиг уурхай гэж ялгалгүйгээр ОУИТБС-ын Дэд зөвлөлд бичил уурхайн төлөөллийг оруулах, орж хамтарч ажилласнаар хариуцлагагүй бичил уурхайг зогсооход хувь нэмэр болно.

- 5.7. ОУИТБС-ын одоо байгаа мэдээллээ сайн ашиглах, жишиг сумын практикийг цааш нь сайжруулах, туршлага солилцох, бие биенээсээ суралцах, сургагч багш нарыг бэлтгэх, сайн ажиллуулах;
- 5.8. Татварын ил тод байдлыг хэрхэн хэмжих вэ гэдгийг тодорхой болгох, орон нутагт төлсөн татварын зарцуулалтыг ил тод болгох;
- 5.9. Аймгуудын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс Дэд зөвлөлийн төсвийг боловсруулах, энэ чиглэлээр санаачилгатай ажиллах;
- 5.10. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр харьцангуй бололцоотой харин хэлбэрийг тодорхой болгох;
- 5.11. Аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийн Дэд зөвлөлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт танилцуулга хийх;
- 5.12. Дэд зөвлөлийн эрх мэдэл, статусыг өргөтгөх, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороодтой хамтран ажиллах;
- 5.13. Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрдэс баялгийн зөвлөлийн зарим чиг үүргийг Дэд зөвлөлд шилжүүлэх, эсхүл 2 зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэх асуудал, орон нутагт олон зөвлөл байхаас сэргийлэх, нэгтгэх боломжийг судлах;
- 5.14. Дэд зөвлөлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа төрийн ямар чиг үүргийн шилжүүлэн хэрэгжүүлэх боломжтой талаар нэг ойлголттой болсны үндсэн дээр боловсруулах;
- 5.15. Жил бүрийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэлэлцэхэд Дэд зөвлөлийг оролцуулах, чиглэл авах, хамтран ажиллах;
- 5.16. Аймаг, сум, Дэд зөвлөл хоорондоо мэдээлэл солилцдог болох;
- 5.17. Дэд зөвлөлийн санхүүжилтийн хараат бус байдлыг хангахад талууд ажиллах;
- 5.18. Дэд зөвлөлийн гишүүн бүрт үүрэг оноох, ажил хариуцуулах байдлаар ажил хэрэгч оролцоог хангахад анхаарах;

6. Компани, бичил уурхай эрхлэгчдэд:

- 6.1. Компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мэдээллийг олон нийтэд тайлагнах, компанийн зүгээс зардалыг гаргах, Дэд зөвлөлтэй энэ ажлыг уялдуулах боломжийг судлах;
- 6.2. Уул уурхайн компаниудад хуулиар суманд оруулах хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тогтоож өгөх асуудлыг шийдвэрлэх;
- 6.3. Бичил уурхай эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг ил тод болгох;

7. Төсөл хөтөлбөрүүдэд:

- 7.1. Мерит зэрэг төслүүдээс төслийн аймгуудын Дэд зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой гэсэн саналын дагуу холбогдох аймгууд төсвөө боловсруулж, үйл ажиллагаагаа төлөвлөх, УУХҮЯ-наас холбогдох албан хүсэлтийг авах;
- 7.2. Мерит зэрэг төслүүдийн бий болгосон 4 аймгуудын мэдээллийн сан, хялбаршуулсан мэдээллийг ОУИТБС-ын мэдээллийн сантай уялдуулах, нэгтгэх асуудлыг анхаарах, цаашид хэн хариуцахыг тодорхой болгох;
- 7.3. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ОУСК-ын Хөгжлийн төлөөх ил тод байдал хөтөлбөр, АМЭП, Мерит болон бусад төслүүдэд ОУИТБС-ын дэд зөвлөлийн чадавхийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахыг хүсэлт болгох;

8. ОУИТБС-ын Ажлын албанд:

- 8.1. Энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдээ саадгүй биелүүлэх бүх боломжийг бүрдүүлэх;
- 8.2. Дэд зөвлөлүүдээс гаргах санал санаачлагыг түргэн шуурхай хянаж, хэрэгжүүлэх талаас нь анхаарах, арга хэмжээ авч ажиллах.

9. Бүх оролцогчид, зохион байгуулагч нарт:

- 9.1. Төв орон нутаг гэлтгүй бүгд цахим орчинд ажиллаж сурах, бэлтгэлтэй оролцох;
- 9.2. Хуулийн төсөл, журманд яг юуг оруулах шаардлагатай байгаагаа зөвлөмж болгох;
- 9.3. Өрөө, өрөөгөөр хуваагдан, хэлэлцүүлэг хийснийг цаашид сайжруулах, бичлэгээ хуваалцах;
- 9.4. Уул уурхай дээр байгаа бүх асуудлыг зөвлөмжиндөө оруулах зохимжгүй;

ОҮИТБС-ын Төвийн бүсийн IV чуулганы оролцогсод